



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/473

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл хүчингүй болгох тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, нөхөн олгох журам"-ын 5.6 дахь заалт, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 605 дугаар магадлал, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 4/2654 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч Хатиган овогт Бат-Эрдэнийн Ундралын ИЭ00009819 сери, 0009819 дугаартай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн нэг жилийн хугацаагаар хүчингүйд тооцсугай.

2. Эх барих, эмэгтэйчүүдийн эмч Б.Ундралын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэх, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлэх, Б.Ундралд эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох эрх үүстэл буюу 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд бүртгэж, оруулахгүй байх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

3. Тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Эх, барих эмэгтэйчүүд судлалын Мэргэжлийн салбар зөвлөл /Б.Мөнхцэцэг/-д эх барих, эмэгтэйчүүдийн эмч Б.Ундралын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай хүчингүй болгосон тухай тус тус мэдэгдэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081543